



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/09/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитор П.Цэцэгдулам Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Ауд. 02. 25 № 117
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Р.БАТБОЛД ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	107,164,170.00	96,137,498.00
35	БАРАА МАТЕРИАЛ	107,164,170.00	96,137,498.00
35100	Түүхий эд материал	31,629,650.00	30,064,650.00
35110	Тусгай зориулалттай материал	31,234,650.00	29,454,650.00
35130	Эм боох материал	395,000.00	610,000.00
35400	Хангамжийн материал	75,534,520.00	66,072,848.00
35410	Бичиг хэргийн материал	3,267,000.00	1,981,300.00
35420	Аж ахуйн материал	51,683,450.00	54,061,050.00
35440	Түлш, шатах тослох материал	2,540,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	11,076,970.00	5,867,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,967,100.00	4,163,498.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,278,261,137.66	1,385,493,354.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,278,261,137.66	1,385,493,354.34
39200	Биет хөрөнгө	1,169,031,137.66	1,274,846,687.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	806,153,065.04	935,041,662.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,168,102.94	-50,622,303.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,800,000.02	-8,400,000.06
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	130,625,190.00	147,896,174.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-98,336,382.26	-103,389,729.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,294,130.70	70,108,040.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,002,223.35	-49,579,220.46
39214	Бусад үндсэн хөрөнгө	407,554,825.00	407,554,825.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-100,889,364.51	-107,362,761.63
39300	Биет бус хөрөнгө	109,230,000.00	110,646,666.66
39301	Програм хангамж	385,000.00	1,885,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-385,000.00	-468,333.34
39303	Бусад биет бус хөрөнгө	109,230,000.00	109,230,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,385,425,307.66	1,481,630,852.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,385,425,307.66	1,481,630,852.34
51	Засгийн газрын хувь оролцоо	1,385,425,307.66	1,481,630,852.34
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	798,038,471.00	798,038,471.00
51200	Хуримтлагдсан үр дүн	187,334,194.61	283,793,473.29
51210	Өмнөх үеийн үр дүн	158,455,372.05	187,587,928.61
51220	Тайлант үеийн үр дүн	158,455,372.05	96,205,544.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	400,052,642.05	399,798,908.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,385,425,307.66	1,481,630,852.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	977,141,885.00	686,323,620.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,721,920.00	6,467,220.82
120	Нийтлэг татварын бус орлого	118,721,920.00	6,467,220.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,861,000.00	4,076,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,261,000.00	4,076,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,600,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	79,860,920.00	2,390,520.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	858,419,965.00	679,856,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	291,033,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	291,033,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69,285,565.00	56,590,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	12,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,285,565.00	44,090,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	789,134,400.00	332,233,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	789,134,400.00	332,233,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	947,424,909.93	590,118,076.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	947,424,909.93	590,118,076.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	828,346,499.55	561,791,133.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,872,101.79	219,132,468.67
210101	Үндсэн цалин	178,577,678.65	219,132,468.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,301,070.14	0.00
210104	Урамшуулал	9,993,353.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,043,491.02	29,767,500.00
210201	Тэтгэврийн даатгал	19,353,113.01	20,947,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,141,935.83	2,205,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,200,831.25	1,764,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	413,291.35	441,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,934,319.58	4,410,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,179,504.81	167,204,706.89
210301	Гэрэл, цахилгаан	8,358,133.23	9,005,081.79
210302	Түлш, халаалт	152,900,466.38	152,025,567.00
210303	Цэвэр, бохир ус	3,920,905.20	6,174,058.10
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,556,098.80	11,913,620.82
210401	Бичиг хэрэг	3,131,275.00	1,988,150.00
210402	Тээвэр, шатахуун	11,890,616.00	5,105,878.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,378,118.80	761,999.82
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	890,000.00	295,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,040,205.00	3,762,593.00
210408	Бараа материал акталсны зардал	31,225,884.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	214,764,240.00	14,743,370.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,942,100.00	363,000.00
210602	Тавилга	20,200.00	0.00

Архангай аймгийн Биеийн тамир,спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	213,000.00
210604	Урсгал засвар	210,801,940.00	14,167,370.00
2107	Томилолт, зочны зардал	1,464,000.00	921,000.00
210702	Дотоод албан томилолт	1,464,000.00	921,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,626,200.00	14,847,426.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,587,550.00	14,796,262.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	29,700.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	697,000.00	0.00
210807	Газрын төлбөр	91,950.00	51,164.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,840,863.13	103,261,041.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,931,688.00	54,562,140.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,991,300.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,917,875.13	48,698,901.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,078,410.38	28,326,942.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,999,000.00	1,160,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,999,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,160,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	114,079,410.38	23,798,793.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	100,959,410.38	23,798,793.11
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,120,000.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	3,368,149.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,368,149.51
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	29,716,975.07	96,205,544.68
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	838,152.51	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	838,152.51	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	28,878,822.56	96,205,544.68

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	798,038,471.00	401,301,937.18	157,206,076.92	1,356,546,485.10
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,249,295.13	1,249,295.13
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	798,038,471.00	401,301,937.18	158,455,372.05	1,357,795,780.23
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-1,249,295.13	0.00	-1,249,295.13
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	28,878,822.56	28,878,822.56
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	798,038,471.00	400,052,642.05	187,334,194.61	1,385,425,307.66
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	798,038,471.00	400,052,642.05	187,334,194.61	1,385,425,307.66
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	253,734.00	253,734.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	798,038,471.00	400,052,642.05	187,587,928.61	1,385,679,041.66
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-253,734.00	0.00	-253,734.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	96,205,544.68	96,205,544.68
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	798,038,471.00	399,798,908.05	283,793,473.29	1,481,630,852.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	863,680,965.00	683,933,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,261,000.00	4,076,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,261,000.00	4,076,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,261,000.00	4,076,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,261,000.00	4,076,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	858,419,965.00	679,856,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	291,033,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	291,033,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69,285,565.00	56,590,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	12,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,285,565.00	44,090,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	789,134,400.00	332,233,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	789,134,400.00	332,233,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	847,038,575.00	530,392,503.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	847,038,575.00	530,392,503.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	727,960,164.62	502,065,560.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,892,510.99	219,132,468.67
210101	Үндсэн цалин	176,598,087.85	219,132,468.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,301,070.14	0.00
210104	Урамшуулал	9,993,353.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,043,491.02	29,767,500.00
210201	Тэтгэврийн даатгал	19,353,113.01	20,947,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,141,935.83	2,205,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,200,831.25	1,764,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	413,291.35	441,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,934,319.58	4,410,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,179,504.81	167,204,706.89
210301	Гэрэл, цахилгаан	8,358,133.23	9,005,081.79
210302	Түлш, халаалт	152,900,466.38	152,025,567.00
210303	Цэвэр, бохир ус	3,920,905.20	6,174,058.10
2104	Хангамж, бараа материалын зардал	37,319,129.80	6,514,577.82
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	653,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,430,616.00	2,565,878.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,499,518.80	761,999.82
210404	Ном, хэвлэл	499,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	890,000.00	295,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,999,995.00	2,238,300.00

2105	Нормативт зардал	4,000,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	166,651,490.00	12,591,103.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,099,500.00	0.00
210602	Тавилга	260,200.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	250,000.00
210604	Урсгал засвар	154,291,790.00	12,341,103.00
2107	Томилолт, зочны зардал	1,464,000.00	921,000.00
210702	Дотоод албан томилолт	1,464,000.00	921,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,429,200.00	13,958,564.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,587,550.00	13,907,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	29,700.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,500,000.00	0.00
210807	Газрын төлбөр	91,950.00	51,164.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,980,838.00	51,975,640.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,989,538.00	51,975,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,991,300.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,078,410.38	28,326,942.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,999,000.00	1,160,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,999,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,160,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	114,079,410.38	23,798,793.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	100,959,410.38	23,798,793.11
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,120,000.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	3,368,149.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,368,149.51
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	16,642,390.00	153,540,597.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,642,390.00	153,540,597.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,642,390.00	153,540,597.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,642,390.00	153,540,597.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,642,390.00	153,540,597.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-16,642,390.00	-153,540,597.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	332,233,200.00	308,434,406.89	23,798,793.11	92.84
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	332,233,200.00	308,434,406.89	23,798,793.11	92.84
4	Бараа, үйлчилгээний зардал	332,233,200.00	308,434,406.89	23,798,793.11	92.84
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,003,500.00	167,204,706.89	23,798,793.11	87.54
18	Гэрэл цахилгаан	12,800,000.00	9,005,081.79	3,794,918.21	70.35
19	Түлш, халаалт	170,800,000.00	152,025,567.00	18,774,433.00	89.01
20	Цэвэр, бохир ус	7,403,500.00	6,174,058.10	1,229,441.90	83.39
34	Эд хогшил худалдан авах	141,229,700.00	141,229,700.00	-	100.00
38	Урсгал засвар	141,229,700.00	141,229,700.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	332,233,200.00	308,434,406.89	23,798,793.11	92.84
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	332,233,200.00	308,434,406.89	23,798,793.11	92.84
104	Орон нутгийн төсвөөс	332,233,200.00	308,434,406.89	23,798,793.11	92.84
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	21.00	21.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00

Архангай аймгийн Биеийн тамир,спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	301,033,200.00	291,741,750.49	9,291,449.51	96.91
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	301,033,200.00	291,741,750.49	9,291,449.51	96.91
4	Бараа, үйлчилгээний зардал	299,599,800.00	290,581,750.49	9,018,049.51	96.99
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,500,000.00	219,132,468.67	1,367,531.33	99.38
6	Үндсэн цалин	220,500,000.00	219,132,468.67	1,367,531.33	99.38
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,767,500.00	29,767,500.00	-	100.00
12	Тэтгэврийн даатгал	20,947,500.00	20,947,500.00	-	100.00
13	Тэтгэмжийн даатгал	2,205,000.00	2,205,000.00	-	100.00
14	ҮОМШӨ ний даатгал	1,764,000.00	1,764,000.00	-	100.00
15	Ажилгүйдлийн даатгал	441,000.00	441,000.00	-	100.00
16	Эрүүл мэндийн даатгал	4,410,000.00	4,410,000.00	-	100.00
22	Хангамж, бараа материалын зардал	7,266,400.00	6,514,577.82	751,822.18	89.65
23	Бичиг хэрэг	653,400.00	653,400.00	-	100.00
24	Тээвэр (шатахуун)	2,890,000.00	2,565,878.00	324,122.00	88.78
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	795,000.00	761,999.82	33,000.18	95.85
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	295,000.00	295,000.00	-	100.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,633,000.00	2,238,300.00	394,700.00	85.01
34	Эд хогшил худалдан авах	250,000.00	250,000.00	-	100.00
37	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	250,000.00	250,000.00	-	100.00
39	Томилолт, зочны зардал	921,000.00	921,000.00	-	100.00
41	Дотоод албан томилолт	921,000.00	921,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	15,561,500.00	15,458,564.00	102,936.00	99.34
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,407,400.00	15,407,400.00	-	100.00
50	Газрын төлбөр	154,100.00	51,164.00	102,936.00	33.20
53	Бараа үйлчилгээний бусад зардал	25,333,400.00	18,537,640.00	6,795,760.00	73.17
54	Бараа үйлчилгээний бусад зардал	25,333,400.00	18,537,640.00	6,795,760.00	73.17
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,433,400.00	1,160,000.00	273,400.00	80.93
70	Бусад урсгал шилжүүлэг	1,433,400.00	1,160,000.00	273,400.00	80.93
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,433,400.00	1,160,000.00	273,400.00	80.93
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	301,033,200.00	291,741,750.49	9,291,449.51	96.91
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	291,033,200.00	287,665,050.49	3,368,149.51	95.56
99	Улсын төсвөөс санхүүжих	291,033,200.00	287,665,050.49	3,368,149.51	95.56

101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-	-	-
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	4,076,700.00	5,923,300.00	-
111	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	4,076,700.00	5,923,300.00	-

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,590,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,590,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,590,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,120,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,470,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,090,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай аймгийн Биеийн тамир,спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Цэцэгдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймаг Биеийн тамир,спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Биеийн тамир спортын газар нь хүн амын эрүүл мэндийг хамгаала, бие бялдарыг чийрэгжүүлэх, өсвөр үе залуучуудад эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэн, биеийн тамир спортоор хичээллэх таатай орчин бүрдүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЭЗ-ийн харъяа орон нутгийн төсвийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайланд онд “Аймгаасаа аваргыг төрүүлье” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын дотоод хяналтын албанаас ажиллагсадын төрийн албанд ажилсан жилийг баталгаажуулах, ажилчдын хувийн хэрэг болон, тушаал шийдвэрийн хууль тогтоомжийн заалт, хувийн хэргийн эмх цээгцтэй байдал, болон үндсэн хөрөнгө, бараа материал, тоног төхөөрөмжийн ашиглалт, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийж заавар, зөвлөмж өгч ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэль сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 633.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 4.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 96.2 сая төгрөгөөр өссөн материалаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	хувь
Бараа материал	107.2	96.2	(11.1)	(10.4)
Үндсэн хөрөнгө	1,278.2	1,385.5	107.3	8.4
Нийт хөрөнгө	1,385.4	1,481.6	96.2	6.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,385.4	1,481.6	96.2	6.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,385.4	1,481.6	96.2	6.9

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал эхний үлдэгдлээс 10.4 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 107.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 42.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 53.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, оны эцэст 96.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 8.4 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1278.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд үнэ төлбөргүй 2.4 сая төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 153.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 48.6 сая төгрөгийн элэгдлээр тус тус буурч 1.385.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 96.2 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	113.4	2.4	(111.0)
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		291.0	291.0
Нэмэлт санхүүжилт	69.3	56.6	(12.7)
Орон нутгийн төсвөөс	789.1	332.2	(456.9)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5.3	4.1	(1.2)
Үйл ажиллагааны орлого	977.1	686.3	(290.8)
Цалин, шимтгэлийн зардал	244.8	248.8	4.0
Бараа ажил үйлчилгээний зардал	441.1	195.0	(246.1)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19.6	14.8	(4.8)
Бараа үйлчилгээний бусад зардал	122.8	103.2	(19.6)
Урсгал шилжүүлэг	119.1	28.3	(90.8)
Хөрөнгийн зардал			-
Үйл ажиллагааны зардал	947.4	590.1	(357.3)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	28.8	96.2	67.4

Архангай аймгийн Биеийн тамир, спортын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 290.8 сая төгрөгөөр буурсан нь өөрийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1167.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 456.5 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 711.1 сая төгрөгөөр хянан баталж тодотголоор 78.0 сая төгрөгөөр бууруулан 633.2 сая төгрөг болсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс 291.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 332.2 сая төгрөг, өөрийн орлогоор 10.0 сая төгрөг нийт 633.2 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр улс, орон нутгийн төсвөөс санхүүжилтийг бүрэн авч өөрийн орлого 4.1 сая төгрөг буюу 5.9 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Төсвийн гүйцэтгэлээр 600.2 сая төгрөгийг зарцуулж 27.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас 12.5 сая төгрөг, Биеийн тамир,спортын улсын хорооноос 44.1 сая төгрөг нийт 56.6 сая төгрөг ирсэн байна. Үүнээс тоног төхөөрөмж худалдан авахад 23.1 сая төгрөг, бөхийн бэлтгэлийн зардалд 2.0 сая төгрөг, биеийн тамир спортын үйл ажиллагаанд 31.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь Монгол Улсын газрын 2020.08.12-ний өдрийн 47 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир спортын улсын хорооны харъяа болсонтой холбоотой улсын төсвөөс 291.0 сая төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2019.05.27-ны өдрийн Б/24 дугаартай захирамжаар Биеийн тамир спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Р.Батболдыг томилсон байна. Харин тайлант онд аймгийн Засаг даргын 2021.05.05-ны өдрийн Б/17 тоот захирамжаар албан тушаалаас нь чөлөөлж тухайн өдрийн Б/18 тоот захирамжаар Л.Бат-Өлзийг томилсон бөгөөд Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021.08.17-ны өдрийн 109/ШШ2021/0030 дугаартай шийдвэрээр Р.Батболд буцаан томилогдож ажилгүй байсан хугацааны тэтгэмжид 3.8 сая төгрөгийг байгууллагын төсвөөс олгосон байна. Энэхүү зөрчилтэй асуудалд Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн хүрээнд аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас хяналт шалгалт хийгдэж Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2 дахь заалтуудыг үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн байна. Иймд аудитаас шийдвэр хүргүүлээгүй болно.

Тайлант онд Ковид-19 цар тахлын үеийн дэглэмтэй холбоотой өөрийн орлогын төлөвлөгөө 5.9 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 83.2 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 633.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 95.6 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тайлант онд нийт 27.1 сая төгрөгийн хэмнэлтийг гаргаж буцаан төвлөрүүлсэн байна.
- Тус байгууллага нь 33.6 сая төгрөгийн балансын үнэтэй фургон маркийн 1 тээврийн хэрэгсэлтэй бөгөөд орон тооны 1 жолоочтой цалингийн зардалд 10.7 сая төгрөг, шатахууны зардалд 3.6 сая төгрөг зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймаг Биеийн тамир,спортын газар нь тайлант хугацаанд оруулбал зохих 139 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, өмч хөрөнгө мөнгө зарцуулсан 104.0 сая төгрөгийн 33 тушаал шийдвэрийг шилэн цахим сайтад байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “... өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан.Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн

хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 27.1 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

Биеийн тамир спортын газрын бөхийн заалны өргөтгөл засвар, цанын баазад био ариун цэврийн газар хийх, худаг гаргах” ажлын тендер аймгийн орон нутгийн өмчийн газарт зохион байгуулагдаж 128.8 сая төгрөгөөр “Девсофт” ХХК гүйцэтгэсэн бөгөөд тайлан балансад тусгасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолын хэрэгжилтыг холбогдох шалгууртай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4.2 сая төгрөгийн зөрчилтэй асуудал илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлээ.

Залруулагдаагүй 2 алдаа, зөрчлийн 4.2 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 6.3 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Албан шаардлага

Тайлант онд Биеийн тамир спортын газрын даргын 2021.09.16-ны өдрийн Б/32 тоот тушаалаар нягтлан бодогч, архив бичиг хэрэг, цахим сан мэдээлэл хариуцсан 3 ажилтанд цар тахалын үед гэрээр ажиллах болсонтой холбоотой цалингийн сангаас 0.3 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж төсөвт зохицуулалт хийлгүйгээр зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх хууль журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

---oOo---

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		1	0.3					1	0.3		
	дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
		1	104.0					1	104.0		
	дүн										
	Нийт дүн	4	108.0	0	0	0	0	4	108.8	0	0